



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/04

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, МУ-ын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “Ой тэмдэглэх арга хэмжээ”-ний тухай Хэг/3105 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Их хурлаас 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр баталсан “Монголд улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэх тухай” 97 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын 1,480,500 (нэг сая дөрвөн зуун наян мянга таван зуу) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээний зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Нэргүйцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ

Аймгийн Засаг даргын 2022 оны 11...  
дүгээр сарын 10.-ны өдрийн 11/14 дугаар  
захирамжийн хавсралт

**МОНГОЛ УЛСАД ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДСАНЫ 30 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ**

<b>АЗДТГ</b>				
Шагайн харваа	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
1-р байр	төг	1	200,000	200,000
2-р байр	төг	1	150,000	150,000
3-р байр	төг	1	100,000	100,000
Медаль	ш	24	8,000	192,000
Өргөмжлөл	ш	3	30,000	90,000
Анонс	м2	15	15,000	225,000
Айраг	л	20	8,000	160,000
<b>Дүн</b>				<b>1,117,000</b>
АХА	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
1-р байр	төг	1	100,000	100,000
2-р байр	төг	1	80,000	80,000
3-р байр	төг	1	60,000	60,000
Өргөмжлөл	ш	3	30,000	90,000
Стикер	ш	1	33,500	33,500
<b>Дүн</b>				<b>363,500</b>
<b>Нийт дүн</b>				<b>1,480,500</b>
<b>АИТХ</b>				
Бөхийн барилдаан	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
1-р байр	төг	1	200,000	200,000
2-р байр	төг	1	150,000	150,000
Шөвгөрсөн бөх	төг	2	100,000	200,000
Өргөмжлөл	ш	4	30,000	120,000
Медаль	ш	4	8,000	32,000
Засуул	хүн	4	20,000	80,000
Давааны мөнгө	төг	16	10,000	160,000
	ш	8	15,000	120,000
	ш	4	20,000	80,000
Бөх тайлбарлагч	хүн	1	30,000	30,000
Хэвийн боов	ш	25	4,500	112,500



Хорхой ааруул	кг	2	25,000	50,000
Ёотон	ш	2	5,000	10,000
Хэв ааруул	кг	2	30,000	60,000
Нэг удаагийн аяга	ш	100	250	25,000
Анонс	м2	6	15,000	90,000
<b>Дүн</b>				<b>1,519,500</b>
<b>Нийт дүн</b>				<b>3,000,000</b>